



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийн 43,000,000 /дөчин гурван сая/ төгрөг, хувьцаа эзэмшигчдээс шилжүүлсэн 707,000,000 /долоон зуун долоон сая/ төгрөг, нийт 750,000,000.0 /долоон зуун тавин сая/ төгрөгийн хөрөнгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Р.Туяацэцэг	1 576 456 000,00	519 552 000,00	2 096 008 000,00	59,89%
2	У.Сийлэн	952 044 000,00	226 986 000,00	1 179 030 000,00	33,68%
3	П.Ганзориг	221 500 000,00	3 462 000,00	224 962 000,00	6,43%
	Дүн	2 750 000 000,00	750 000 000,00	3 500 000 000,00	100,00%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000507